**ДОРНОГОВЬ АЙМАГ**
**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 07 өдөр Дугаар А/195 Борхойн тал

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны “Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөг батлах тухай” 07/34 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1 нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр холбогдох хууль тогтоомжийн дагуу танхимын хэлбэрээр зохион байгуулахыг сумын газрын даамал (Д.Жавзан)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын тамгын газрын дарга (М.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.САЙНБАЯР

44010326 445

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

Сумын Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/195 дугаар захирамжийн хавсралт

# ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

| № | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Эзэмшүүлэх газрын байршил | Хэмжээ м.кв | Зориулалт | Эзэмшүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | 4870492 | Жаргалант баг | 10000 | 1606: ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор | 15 жил |

--- o0o ---